

Өсвөр насны сурагчдын өөрийн үнэлэмжийг Розенбергийн аргаар судалсан дүн

Дэлгэрмаа Э.¹, Сарантуяа Д.², Бямбажаргал Д.¹, Шинэдолгор Ц.²

¹“Ач” Анагаах ухааны их сургууль

²Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль

e-mail: delgermaa@ach.edu.mn

Abstract

The study results of the self-esteem of an adolescent students using the Rosenberg's method

Delgermaa E.¹, Sarantuyaa D.², Byambajargal D.¹, Shinedolgor Ts.²

¹“Ach” Medical University

²University of Sociology and Psychology

e-mail: delgermaa@ach.edu.mn

Background

According to global estimates, one in seven adolescents aged 10–19 (14%) experiences mental health issues, most of which remain undiagnosed and untreated. Self-esteem is closely associated with adolescent mental health, affecting their academic performance, relationships, and emotional well-being.

Objective

This study aimed to assess the self-esteem levels of middle school students using Rosenberg's Self-Esteem scale (RSES).

Material and Methods

A cross-sectional study was conducted among 154 students from grades 6 to 9 in a general education school in Ulaanbaatar. The Rosenberg's Self-Esteem scale which has a standard mean score of approximately 22, was used for assessment. Scores below ≤ 14 indicate low self-esteem, scores between 15–25 indicate average self-esteem, scores under ≥ 26 indicate high self-esteem. The Ethics committee of the University of Sociology and Psychology approved this study. Data were analyzed using Microsoft Excel and SPSS-23, applying frequencies, descriptive statistics, chi-square tests, one-sample T-tests to compare the mean score with the standard value, one-way ANOVA to examine differences between groups, and correlation analysis. Statistical significance was considered at $p \leq 0.05$.

Results

The students mean self-esteem score was 17.8 (SD $\pm$ 4.42), significantly lower than the standard score of 22 ($p < 0.001$), supporting our hypothesis. Statistically significant differences in self-esteem were found between grades 6, 8, and 9 ($p < 0.05$), while no significant differences were observed by gender or age ($p > 0.05$). Among the participants, 24.7% ($n=38$) had low self-esteem (score ≤ 14), 72.1% ($n=111$) had average self-esteem (scores 15–25), and only 3.2% ($n=5$) demonstrated high self-esteem (score ≥ 26).

Conclusion:

The self-esteem of middle school students was significantly lower than the standard average.

Nearly one in four students demonstrated low self-esteem, suggesting the need for early interventions to support the mental well-being of adolescents.

Key words: High self-esteem, Low self-esteem, Rosenberg's Self-Esteem scale, Self-esteem, The standard score of self-esteem

Pp. 47-53, 10, Table 1, Figure 4, References 15

Үндэслэл

2021 оны байдлаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас “Өсвөр нас бол өвөрмөц онцлогтой бөгөөд хүний төлөвших, сэтгэцийн хувьд эрүүл сайн сайхан байхыг шийдвэрлэх гол үе шатны нэг юм. Өсвөр насныхныг бэрхшээлээс хамгаалах, нийгэм-сэтгэл санааны боловсрол, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй байлгах нь насанд хүрсэн үед тэдний эрүүл мэнд, сэтгэцийн сайн сайхан байдалд нэн чухал юм” гэж албан ёсоор мэдээлсэн байна [1].

Дэлхий даяар 10-19 насныхны 7 хүүхэд тутмын 1 нь (14%) нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай тулгардаг гэсэн тооцоо байдаг ч эдгээр нь ихэвчлэн уг асуудлыг илрүүлээгүй, оношлоогүй, эмчлэгдээгүй тэр хэвээр үлдэж байна гэж судлаачид үзсэн байна [1]. Өсвөр нас бол сэтгэцийн сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой нийгмийн болон сэтгэл хөдлөлийн зөв дадал зуршлыг хөгжүүлэх чухал үе юм. Энэ үед гэр бүл, сургууль, олон нийтийн зүгээс өсвөр насных хүүхдүүдийг хамгаалах, дэмжих орчин чухал. ДЭМБ-аас өсвөр насныхны өвчлөл, хөгжлийн бэрхшээлийн гол шалтгаануудын нэг нь сэтгэл гутрал, айдас түгшүүр, зан үйлийн эмгэг гэж мэдээлжээ [1, 2]. Гэтэл энэ эмгэгүүдийг үүсгэдэг асуудлуудын нэг тал нь өөрийгөө үнэлэх үнэлэмж доогуур байхтай холбоотой юм.

Иймээс өсвөр насанд өөрийн үнэлгээг үнэлэх нь маш чухал юм. Өсвөр насны хүүхдүүдийн өөрийн үнэлгээ сайн байх нь сэтгэцийн ба бие махбодын эрүүл мэндийг сайжруулж, нийгмийн эсрэг (антисошиал) зан үйл буурдаг, гэмт хэргийн гаралтын

түвшин багасдаг зэрэг ач холбогдолтой байдаг гэж олон улсын судлаачид үзжээ [4].

Судалгааны зорилго

Өсвөр насны хүүхдийн өөрийн үнэлгээг судлах зорилгын хүрээнд дараах зорилтыг тавив. Үүнд:

1. Розенбергийн өөрийн үнэлгээ-ний аргаар дундаж оноог тодорхойлж, нас, хүйс, ангиар харьцуулах;
2. Розенбергийн өөрийн үнэлгээний аргын түвшинг тооцож, ангиар харьцуулах;

Судалгааны хамарсан хүрээ

Нийслэлийн Ерөнхий боловсролын нэгэн сургуулийн 6-9 ангийн нийт 154 сурагч

Судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн

Судалгааг нэг агшины судалгааны загвараар хийв. Судалгаанд “Розенбергийн өөрийн үнэлгээ” (РӨҮ)-ний асуумжийг (10 асуулт) ашигласан. М.Розенбергийн үнэлгээний стандарт дундаж оноо нь ойролцоогоор 22 юм. 14-аас доош оноо нь өөрийн үнэлэх үнэлгээ бага, 15-25 оноо нь дундаж, 26-аас их оноотой байвал өндөр түвшинтэй байна гэж үнэлдэг [5]. 2024 оны 02 сард Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль (НССДС)-ийн эрдмийн зөвлөл ба ёсзүйн хорооны хурлаар судалгааг хийх зөвшөөрлийг авч, ёсзүйн хэм хэмжээг баримталж, батлагдсан сэдэв, аргачлалын дагуу Монгол улсын хууль тогтоомж, олон улсын удирдамж, зөвлөмжийн хүрээнд судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг Microsoft Excel, SPSS-23 программ дээр frequencies, descriptive, chi-square, one sample T-test-ээр боловсруулалтаар жишиг дундаж оноог харьцуулах, бүлэг хоорондын ялгааг one way ANOVA, бүлэг хоорондоо хамаарал

байгаа эсэхийг корреляцийн арга ба статистикийн бусад аргаар боловсруулав. Бүлэг хоорондын ялгааг $p \leq 0.05$ байсан тохиолдолд статистик магадлал бүхий ялгаа байна гэж үзсэн.

Үр дүн

Судалгаанд нийт 154 сурагч оролцов. Үүнээс эрэгтэй 50.6% ($n=78$) эмэгтэй 49.4% ($n=78$) сурагчид байв. Насны хувьд 11-15 насны сурагчид хамрагдсан бөгөөд сурагчдын дундаж нас 12.91 ($CX \pm 1.3$) байсан бөгөөд 14.9% ($n=23$) нь 11 настай, 27.3% ($n=42$) нь 12 настай, 24.7% ($n=38$) нь 13 настай, 18.2% ($n=28$) нь 14 настай, 14.9% ($n=23$) нь 15 настай байлаа. Судалгаанд 6-р ангиас 27.7% ($n=43$), 7-р ангиас 29.1% ($n=44$) 8-р ангиас 17.6% ($n=29$) 9-р ангиас 25.7% ($n=38$) сурагч оролцсон.

Бидний судалгаанд ашигласан “Розенбергийн өөрийн үнэлгээ”-ийн аргын баталгаат чанарын буюу кронбах альфа коэффициент нь $\alpha=0.717$ байв.

“Розенбергийн өөрийн үнэлгээ”-ний аргаар судалсан судалгааны ($N=154$) үр дүнд 10 асуултын дундаж оноо (ДО) нь 17.8 (стандарт хазайлт - $CX \pm 4.42$) байлаа. Бидний судалгаанд хамрагдсан 6-9 дугаар ангийн сурагчдын хувьд илэрсэн 17.8 ($CX \pm 4.42$) дундаж оноог one sample T-test-ийн аргаар РӨҮ-ний жишиг дундаж оноо болох 22-той харьцуулахад статистик магадлал бүхий ялгаатай ($p < 0.001$) бага байгаа нь илэрсэн.

РӨҮ-ний дундаж оноог 10 асуултаар тус бүр тооцоолоход хамгийн бага оноотой асуулт нь 2-р буюу “Заримдаа би өөрийгөө бүх талаараа сайн байж чаддаггүй гэж боддог” гэсэн асуултад ДО=0.94 ($CX \pm 0.4$), 8-р буюу “Би илүү нэр хүндтэй байхыг хүсдэг.” гэсэн асуулт ДО=1.11 ($CX \pm 0.3$) байсан. Харин хамгийн өндөр оноотой нь 3-р буюу “Надад хэд хэдэн сайн чанар байдаг гэдгийг мэдэрдэг” гэх асуулт ДО=2.4 ($CX \pm 0.3$) байгаа нь тодорхойлогдсон (Зураг 1).




Figure 1. The average score of each question for RSES

РӨҮ-ний аргын дундаж оноог ангиар нь 6-р ангийн дундаж оноо нь 18.74 ($CX \pm 4.91$), 7-р ангийнх 17.2 ($CX \pm 4.27$), 8-р ангийнх 18.79 ($CX \pm 3.59$), 9-р ангийнх 16.66 ($CX \pm 4.34$) байсан бөгөөд нэг чигийн Ановогийн

аргаар тооцоход 6-р болон 9-р ангиудын хооронд статистик магадлал бүхий ялгаатай ($p < 0.05$), бусад ангиудын хооронд статистик магадлал бүхий ялгаа ($p > 0.05$) байхгүй байсан (Зураг 2).

Розенбергийн өөрийн үнэлгээний аргын дундаж оноог насаар нь бүлэглэж гаргахад 11 настай сурагчдын дундаж оноо нь 18.6 ($CX \pm 5.37$), 12 настай сурагчдын 18.2 ($CX \pm 4.32$), 13 настай сурагчдын 17.7 ($CX \pm 4.43$), 14 настай сурагчдын 17.9 ($CX \pm 3.94$),

15 настай сурагчдын 16.3 ($CX \pm 4.84$) байсан. Хэдийгээр өөрийн үнэлгээний онооны хувьд нас хоорондоо статистик магадлал бүхий ялгаа ($p > 0.05$) байгаагүй боловч нас ахих тусам бага зэрэг буурсан үзүүлэлт илэрсэн (Зураг 3).




Figure 2. The average score of RSES (by grade)




Figure 3. The average score of RSES (by age)

Розенбергийн өөрийн үнэлгээний аргын дундаж оноог хүйсээр гаргахад эрэгтэй сурагчдын дундаж оноо нь 18.3 ($CX \pm 4.07$), эмэгтэй сурагчдын 17.3 ($CX \pm 4.7$) байсан бөгөөд хүйсийн хувьд статистик магадлал бүхий ялгаа ($p > 0.05$) илрээгүй.




Figure 4. The average score level of RSES (%)

Розенбергийн аргаар өөрийн үнэлгээг судлахад нийт сурагчдын ($N=154$) дунд 26-аас дээш оноотой буюу өндөр түвшингийн оноотой сурагч 3.2% ($n=5$) байна. Дундаж түвшин буюу 15-25 оноотой сурагчдын эзлэх

хувь 72.1% ($n=111$), бага түвшний оноотой (14-ээс доош оноотой) сурагчид 24.7% ($n=38$)-ийг эзэлж байв (Зураг 4). РӨҮ-ний бага, дунд, өндөр түвшнийг ангиар нь crosstab аргаар тооцоход 6-р ангийн сурагчдын 23.3% ($n=10$), 7-р ангийн 27.3% ($n=12$), 8-р ангийн 17.2% ($n=5$), 9-р ангийн 28.9% ($n=11$) нь тус тус бага түвшинтэй байсан. Нийт сурагчдын дунд 24.2% нь өөрийн үнэлэмж бага түвшинтэй байсан;

6-р ангийн сурагчдын 67.4% ($n=29$), 7-р ангийн 70.5% ($n=31$), 8-р ангийн 82.8% ($n=24$), 9-р ангийн 71.1% ($n=27$) дунд түвшинтэй байсан. Харин 6-р ангийн хувьд 9.3% ($n=4$), 7-р ангийн 2.3% ($n=1$) нь тус тус өндөр түвшинтэй байлаа. Бага, дунд, өндөр түвшинтэй сурагчдын эзлэх хувиар ангиудын хооронд статистик магадлал бүхий ялгаа ($p > 0.05$) байхгүй боловч 9-р ангид бага түвшинтэй сурагчдын эзлэх хувь хамгийн ихээр (28.9%) нэмэгдсэн байгаа нь тодорхойлогдов (Хүснэгт 1).

Table 1. The levels of RSES (by grade and gender, %)

Variable	Low SE level (%)	Average SE level (%)	High SE level (%)
6th grade	23.3	67.4	9.3
7th grade	27.3	70.5	2.3
8th grade	17.2	82.8	-
9th grade	28.9	71.1	-

Хэлцэмж

Бидний судалгааны “Розенбергийн өөрийн үнэлгээ”-ний аргын баталгаат чанарын буюу кронбах альфа коэффициент нь $\alpha=0.717$ байгаа нь тогтоогдсон. Вьетнам улсын Канто хотын 1,149 сурагчдын (дундаж нас 16.1) дунд хийгдсэн судалгааны үр дүнд кронбах альфа коэффициент нь $\alpha=0.77$ байсан бол Америкийн Нэгдсэн Улсын өмнөд Калифорни мужийн 1,248 сурагчдын дунд хийгдсэн судалгааны үр дүнд кронбах альфа коэффициент нь $\alpha=0.79$ байгаа нь бидний судалгааны үр дүнтэй төстэй үр дүн үзүүлсэн байна [2, 6].

Бидний судалгааны үр дүнд РӨҮ-ний дундаж оноо 17.8 байгаа нь хэдийгээр РӨҮ-ний жишиг дундаж оноо болох 22-той харьцуулахад [5] статистик магадлал бүхий ялгаатай ($p<0.001$) бага байгаа нь илэрсэн боловч Вьетнам улсын Канто хотын 1,149 сурагчдын дунд хийгдсэн судалгааны үр дүнгийн РӨҮ-ний дундаж оноо 17.56-тай ойролцоо үр дүн үзүүлсэн байна [2].

Розенбергийн ӨҮ-ний аргыг ашиглан Энэтхэг улсын охидын коллежийн 17-21 настай, 354 оюутнуудыг судалгаанд хамруулахад өөрийгөө үнэлэх үнэлэмж нь нас, төрөлтийн эрэмбэ, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох, интернет ба сошиал медиа хэрэглээ, бусдаас хараат байдал, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ, өөрийгөө хянах чадвар зэрэгтэй хамааралтай эсэхийг судалсан. Энэ судалгааны үр дүнд хичээлийн бус цагаар олон нийтийн үйл ажиллагаанд оролцох нь нэмэгдэх тусам сурагчдын өөрийгөө үнэлэх үнэлэмжийг сайжруулдаг. Харин интернет ба сошиал медиа хэрэглээ нь өөрийгөө үнэлэх үнэлэмжид сөргөөр нөлөөлдөг

гэсэн судалгааны үр дүн илэрсэн. Ихэнх оролцогчид өөрийгөө үнэлэх үнэлэмж бага (76.27%), дунд зэргийн оноотой (23.73%) байсан. Өөрийн үнэлгээний өндөр оноо хэн ч аваагүй нь өөрийгөө үнэлэх асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байгааг илрүүлсэн учраас Амьдрах ухааны боловсролын хичээлийг санал болгосон байна [7].

Бидний судалгааны үр дүнд бага түвшний оноотой 24.7% сурагчид байгаа (Зураг 4) нь Энэтхэг улсын охидын коллежийн дээрх судалгааны үр дүн 76.27%-иэс даруй 3.08 дахин бага; Тайландын Фаяо их сургуулийн 729 оюутны дунд хийсэн судалгааны үр дүн 52.4%-өөс 2.12 дахин бага байсан бол харин Вьетнам улсын Канто хотын 1,149 сурагчдын бага түвшний үнэлгээтэй 19.4% сурагчид эзэлж байгаа судалгааны үр дүнтэй ойролцоо байсан [2, 7, 8].

Тайланд улсын их сургуулийн 729 оюутныг Розенбергийн ӨҮ-ний аргаар судлахад гэр бүлтэйгээ сайн харилцаатай байх нь өөрийн үнэлгээнд статистик магадлал ($p<0.05$) бүхий зөрөг нөлөө үзүүлдгийг тогтоожээ [8].

Турк улсад өсвөр насны 13-17 насны 221 хүүхэд оролцсон судалгааны үр дүнд сэтгэл санааны асуудал (emotional problems)-ын өндөр түвшин ба сошиал медиад донтох донтолтын өндөр түвшинтэй хүүхдүүдийн өөрийн үнэлгээний бага түвшинтэй хамааралтай байсан [9].

Энэтхэгт хийгдсэн судалгааны үр дүнд сэтгэц нөлөөт бодис хэрэглэдэг хүүхдүүдийн (8-15 настай) өөрийгөө үнэлэх үнэлэмж нь огт хэрэглэдэггүй хүүхдүүдийнхээс доогуур түвшинд байгаа нь тодорхойлогдсон. Сэтгэц нөлөөт

бодисын хэрэглээ ихсэх тусам өөрийн үнэлэмж буурч байсан [3].

Энэтхэгт 252 сурагчдын (дундаж нас 14) сэтгэл зүйн сургалт тренинг явуулсны дараа сургуулийн гаралтай айдас түгшүүр мэдэгдэхүйц буурсан. Мөн сурагчдын өөрийгөө үнэлэх үнэлэмж сайжрахын хэрээр дасан зохицох түвшин бас сайжирч байжээ [10].

ОХУ-д чихрийн шижин, уушгины астма, эпилепси өвчтэй өсвөр насны хүүхдүүдийн өөрийн үнэлгээг Розенбергийн ӨҮ-ний аргаар эрүүл өсвөр насны үе тэнгийнхтэй харьцуулан судлахад: эпилепситэй өсвөр насныхны ӨҮ хамгийн бага байлаа. Ялангуяа эпилепси өвчинтэй хүүхдүүдийн хувьд өөрийгөө үнэлэх үнэлэмж нь өвчний үе шат буюу илүү хүнд түвшин, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдалтай хамааралтай байж болохыг урьдчилан таамаглажээ [11].

Сэтгэл гутралын 77, сэтгэлийн түгшүүрийн талаарх 18 судалгааг судлахад өөрийн үнэлгээнд сэтгэл гутрал нөлөөлөхөөс ($\beta = -.08$), өөрийн үнэлгээ сэтгэл гутралд нөлөөлөх ($\beta = -.16$) нөлөө нь хамаагүй илүү хүчтэй байсан. Айдас, түгшүүрийг урьдчилан таамаглах боломжинд өөрийн үнэлгээ нөлөөлөх түвшин ($\beta = -.10$)-ээс өөрийн үнэлгээг урьдчилан таамаглах боломжинд айдас түгшүүр нөлөөлөх түвшин ($\beta = -.08$) илүү байсан. Өөрийгөө үнэлэх үнэлэмж нь сэтгэл гутралд сөргөөр нөлөөлж байв. Энэ нөлөө нь хүйс, нас, өөрийн үнэлгээг хэмжих арга, сэтгэл гутралын хэмжүүр, үнэлгээний хоорондох хугацаа зэргээс төдийлөн хамаардаггүй гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Өөрийгөө үнэлэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд нь сэтгэл гутралд орох эрсдэлийг бууруулахад тустай байж болох юм гэж эрдэмтэд дүгнэсэн байна [12].

Ийнхүү өөрийн үнэлэмж нь сэтгэл гутрал, айдас түгшүүр, сэтгэл нөлөөт бодисын хэрэглээ, сошиал медиад донтох зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалд шууд нөлөөлдөг болох нь судалгаагаар тодорхойлогдсон байна.

Гэтэл бидний судалгааны үр дүнд өөрийн үнэлэмж дэлхийн дундаж онооноос илт доогуур, бас 4 хүүхэд тутмын 1 нь өөрийн үнэлэмж бага түвшинд байгаа нь ДЭМБ-ын мэдээлсний дагуу дэлхий даяар 10-19 насны өсвөр насны 7 хүүхэд тутмын 1 нь (14%) нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай тулгардаг гэсэн тооцооноос даруй 1.76 дахин өндөр байгаа нь өсвөр насны хүүхдүүдийн өөрийн үнэлгээ ба сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай холбож судлах, мөн сургуулийн орчинд өсвөр насны хүүхдүүдэд зориулсан өөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх сэтгэл зүйн сургалт, тусламж үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байгааг илтгэж байна.

Сэтгэл зүйн үүднээс бол хүүхдийн өөрийн үнэлгээ нь тухайн үеийн бодит боломжоос яльгүй дээгүүр байж, түүний өөрийн хөгжил, хүмүүжлийг эрчимжүүлж байх ёстой. Өөрөөр хэлбэл хүүхэд өөрийгөө бодитой үнэлснийхээ үндсэн дээр өнөөдөр би юуг хийж чадаж байна вэ? гэдгээ баттай мэдэхээс гадна өнөөдөр хараахан хийж чадахгүй ч маргааш хийж чадах зүйлээ баримжаалж харсан, түүнийг хийж чадна гэсэн итгэл тэмүүлэлтэй байх нь чухал [10].

Төрөл бүрийн хүчирхийлэлд өртөж байсан хүмүүст ажиглагдаж байгаа нийтлэг онцлогуудын нэг бол өөртөө итгэлгүй байдал, бүрэг, үзэл бодлоо илэрхийлэх чадвар сул байдаг явдал юм. Тиймээс сурган хүмүүжлийн явцад бүрэг занг засах, итгэлтэй харилцааны техник эзэмшихэд өсвөр насныханд туслах, өөрийгөө илэрхийлэх хүсэл сэдлийг өдөөж өгөх асуудал нэн чухлаар тавигдаж байна [13].

Дүгнэлт:

1. 6-9 дүгээр ангийн сурагчдын өөрийн үнэлэмжийн дундаж оноо 17.8 ($СХ \pm 4.42$) байсан нь РӨҮ-ний дэлхийн жишиг дундаж 22-оос статистик магадлал бүхий ($p < 0.001$) бага байлаа.
2. 6-р ба 9-р ангийн сурагчдын хооронд ялгаа ($p < 0.05$) илэрсэн бөгөөд нас, хүйсийн хувьд ялгаа байгаагүй ($p > 0.05$) болно.

3. Нийт сурагчдын 24.7% буюу 4 сурагч тутмын нэг нь өөрийн үнэлэмж бага түвшинтэй байгаа нь ДЭМБ-ын мэдээлсний дагуу дэлхий даяар 10-19 насны өсвөр насны 7 хүүхэд тутмын 1 нь (14%) нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай тулгардаг гэсэн тооцооноос даруй 1.76 дахин өндөр байна. Харин 72.1% нь дунд, 3.2% нь хэт өндөр түвшний өөрийн үнэлэмжтэй байв.

Талархал

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн НССДС-ийн сэтгэл судлалын тэнхмийн багш Ц.Шинэдолгор, нийслэлийн ЕБС-ийн сэтгэл зүйч Г.Энхболд, судалгаанд хамтарч оролцсон нийт оролцогчдодоо талархал илэрхийлье.

Ном зүй

1. World health organization. Mental health of adolescents - World Health. Nov 17, 2021. <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/adolescent-mental-health>
2. Nguyen DT, Wright EP, Dedding C, Pham TT and Bunders J. Low Self-Esteem and Its Association with Anxiety, Depression, and Suicidal Ideation in Vietnamese Secondary School Students: A Cross-Sectional Study. *Front. Psychiatry*. 2019;10:698. doi: 10.3389/fpsy.2019.00698
3. Agarwala S, Singh SS. Self-esteem among substance abusers: A behavior modification approach. *Journal of Psychosocial Research*, 2010;5(1), 101–109.
4. Orth UR, Richard W. Is High Self-Esteem Beneficial? Revisiting a Classic Question. *American Psychologist*. 2022;77(1): 5–17. doi:10.1037/amp0000922
5. Клиник практикт хэрэглэх аргачлалууд (орч.Б.Туяа). УБ, “Соёмбо Принтинг” ХХК. 2012. х. 44-46, 64,65
6. Supple AJ, Su J, Plunkett SW, Peterson GW, Bush K. R. Factor structure of the Rosenberg Self-Esteem Scale. *Journal of Cross-Cultural Psychology*, 2013;44:748-764. doi:10.1177/0022022112468942
7. Swati Y Bhav, Pradeep M, Mota J, et al. Self-esteem: A study on the relationship between self-esteem and factors affecting student life. *J Pediatr Neonatal Care*. 2024;14(1):22-28. doi: 10.15406/jpnc.2024.14.00536
8. Auttama N, Seangpraw K, Ong-Artborirak P, Tonchoy P. Factors Associated with Self-Esteem, Resilience, Mental Health, and Psychological Self-Care Among University Students in Northern Thailand. *J Multidiscip Health*. May 2021;27(14):1213-1221. doi: 10.2147/JMDH.S308076.
9. Acar IH, Avclar G, Yazici G, Bostanci S. The roles of adolescents' emotional problems and social media addiction on their self-esteem. *Current Psychology: A Journal for Diverse Perspectives on Diverse Psychological Issues*. 2022;41(10):6838-6847. <https://doi.org/10.1007/s12144-020-01174-5>
10. Malik A, Anand M, Karamvir Batra A. Effect of life skill training on academic anxiety, adjustment and self-esteem levels in early adolescents. *Journal of the Indian Academy of Applied Psychology*, 2012;38(1):188–192.
11. Zashikhina A, Hagglof B. Self-esteem in adolescents with chronic physical illness vs. controls in Northern Russia. *International Journal of Adolescent Medicine and Health*. 2014;26(2):275–281. <https://doi.org/10.1515/ijamh-2013-0507>
12. Sowislo JF, Orth U. Does low self-esteem predict depression and anxiety? A meta-analysis of longitudinal studies. *Psychological Bulletin*. 2013;139(1):213–240. <https://doi.org/10.1037/a0028931>
13. О. Мягмар. Судлаач багшийн гарын авлага. УБ, 2013. х.86-90.

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор, профессор
Б.Сүвд*